



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/151

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1.Коронавирус (COVID-19) цартахлын өвчлөлийн тархалт нэмэгдэж хамгаалах хэрэгслийн нөөц дутмаг байгаа тул аймгийн хэмжээнд хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэх тооцоог хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 64,400,000 (Жаран дөрвөн сая дөрвөн зуун мянга) төгрөгийн зардлаас 14,000,000 (Арван дөрвөн сая) төгрөгийг эрүүл мэндийн тусгай зориулалтын шилжүүлгийн багцаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т, үлдэгдэл 50,400,000 (Тавин сая дөрвөн зуун мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц сангаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-т тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100326

Аймгийн Засаг даргын 2021 оны 03
дугаар сарын 30-ны өдрийн 41/151 дүгээр
захирамжийн хавсралт



КОВИД-19 ХАЛДВАРЫН ҮЕД ШААРДЛАГАТАЙ
ХАЛДВАР ХАМГААЛЛЫН ХУВЦАС
ХЭРЭГСЛИЙН ТООЦОО

№	Халдвар хамгааллын хувцас хэрэгслийн нэр төрөл	Хэмжих нэгж	Шаардлагатай тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Нэг удаагийн халад	ш	4000	5000	20,000,000
2	Комбинзоны иж бүрдэл	ш	1500	22000	33,000,000
3	Нэг удаагийн малгай (Хайрцаг 100ш)	Хайрцаг	100	8000	800,000
4	Нүүрний хаалт	ш	2000	800	1,600,000
5	Үзлэгийн бээлий (Хайрцаг 50 хос)	Хайрцаг	200	38000	7,600,000
6	Тамедин (ам зайлах)	ш	1000	1400	1,400,000
Нийт дүн					64,400,000